



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 06 сарын 28 өдөр

Дугаар

A/351

Хэрлэн сум

Хүндэтгэл үзүүлэхэд зориулж,
хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.5, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Сангийн сайдын 2021 оны 61 дугаар тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Ерөнхийлөгч 2022 оны 5 дугаар сарын 27-оос 2022 оны 5 дугаар сарын 28-д Хэнтий аймагт айлчилсантай холбогдуулан хүлээн авч, хүндэтгэл үзүүлэхэд зориулан 11,501,600 (арван нэгэн сая таван зуун нэг мянга зургаан зуун) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Хөрөнгө зарцуулалтын тооцоог хавсралтаар баталсугай.

3. Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг Засаг даргын нөөц сангийн урьдчилан төлөвлөж төсөвт тусгах боломжгүй нэг удаагийн шинжтэй арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Ганбаатар)-д, гүйцэтгэлийг зохион байгуулж, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

Аймгийн Засаг даргын 2022 оны
... дугаар сарын ...-ны
захирамжийн хавсралт

Шаардагдах зардлын тооцоо

№	Зардлын нэр	Тоо	Нэг бүрийн үнэ	Бүгд үнэ
1	Хоол	70 хүн	15.000*4	4.200.000
2	Буудал	24 өрөө	120.000*2*1 90.000*2*23	4.140.000
3	Аймгийн Засаг даргын хүндэтгэлийн зоог	65 хүн	48.640	3.161.600
Дүн				11.501.600